



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

┌ Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, 3 нэрийн, нийт 327,380,406.30 (гурван зуун хорин долоон сая гурван зуун наян мянга дөрвөн зуун зургаан төгрөг гучин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал О.Төмөрхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;


2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт



**"ЗАМЫН-ҮҮДИЙН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт бүртгэх дүн (төгрөг)
1	Дулааны шугам (Замын Үүд сумын Борхойн багт)	2023	910	м	324,016.93	294,855,406.30
2	Түгээх дэлгэц	2024	5	ш	1,015,000.00	5,075,000.00
3	Түгээлтийн удирдлагын самбар/процессор/	2024	5	ш	5,490,000.00	27,450,000.00
Нийт дүн						327,380,406.30
						(гурван зуун хорин долоон сая гурван зуун наян мянга дөрвөн зуун зургаан төгрөг гучин мөнгө)